

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА, СУРГАМЖ

Ц.Ганболд

*ДХИС-ийн Эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн Хилийн аюулгүй
байдал судлалын төвийн ахлах
судлаач, доктор (Ph.D),
профессор, хурандаа*

Б.Мөнгөнбагана

*ДХИС-ийн Хилийн албаны
сургуулийн Хилийн албаны
тэнхимийн профессорын үүргийг
түр орлон гүйцэтгэгч,
докторант,
дэд хурандаа*

Товч агуулга: Аливаа улсын хилийн аюулгүй байдал нь улсын хилээ хамгаалах цогц үйл ажиллагаагаар хангагддаг бөгөөд тухайн улсад тохирсон өвөрмөц үйл ажиллагааны онцлогоор ялгарч байдаг.

Энэхүү илтгэлд дэлхийн зарим улс орнуудын хилийн аюулгүй байдлаа хангах, хил хамгаалалтын чиглэлээр авч хэрэгжүүлж буй туршлагыг судалсан.

Түлхүүр үгс: Хилийн аюулгүй байдал, улсын хил, хил хамгаалалт

Аливаа улс үндэстний хувьд хилийн аюулгүй байдлаа хангана гэдэг нь юуны өмнө төрийн тусгаар тогтнол, газар

нутгийнхаа бүрэн бүтэн байдал, ард иргэдийнхээ оюун санааны нэгдмэл чанарыг хилийн орон зайд хамгаалан бэхжүүлэхээс эхлээд өөрийн ашиг сонирхол, хилийн халдашгүй дархан байдлыг бусдаар хүлээн зөвшөөрүүлэх төдийгүй түүний баталгаатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй олон талтай, баялаг агуулгатай улс төр-дипломат, тагнуул, цэрэг, эдийн засгийн цогц бодлого, арга хэрэгсэл, үйл ажиллагааны нэгдэл юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах бодлогыг сонгох нь ихэвчлэн хилийн тодорхой онцлогууд болох: хилийн урт, хил орчмын газар орны онцлог, хил дамнасан урсгалын ачаалал, зэргэлдээ нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, соёлын шинж чанар, аюулгүй байдлын тулгамдсан бэрхшээл зэргээр тодорхойлогддог. Хилийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ хил дамнасан эрчимтэй урсгалыг үр дүнтэй зохицуулах асуудал нь олон улс орнуудад тулгарч байна. Хилийн аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж буй зарим улс, орнуудын туршлага судалсан. Үүнд:

1. БНХАУ-ын хил хамгаалалт:

БНХАУ нь Монгол Улсын хөрш бөгөөд түүний төрийн бодлого үйл ажиллагаанаас манай улсын үндэсний аюулгүй байдал, ялангуяа төрөөс улс орны тусгаар тогтнол бүрэн эрх, нутаг

дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдлыг хангах бодлого, үйл хэрэгт сөргөөр нөлөөлж ирсэн түүхтэй. Энэ шинж байдал, зүй тогтол нь тус улсын ирээдүйн хувь заяа, хөгжил эх орны аюулгүй байдал, тэр дотроос улсын хил, хил орчмын нутагт үндэсний аюулгүй байдлыг хангах таатай нөхцөл бүрдүүлэхэд хүчтэй нөлөөлсөн хэвээр байна (Ш.Арвай, А, Д, & Н, 2016).

Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1949 оны 10 дугаар сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон. Хоёр талын харилцаа 1949-1962 онд шинээр төлөвшин хөгжиж, Монгол Улс, БНХАУ-ын хилийн гэрээг анх 1962 онд байгуулж, 1988, 2010 онд шинэчлэн батламжилж, Монгол-Хятадын хилийн нэг дэх удаагийн хамтарсан шалгалтыг 1982-1984 онд, хоёр дахь удаагийн хамтарсан шалгалтыг 2001-2004 онд зохион байгуулсан (П.Сүндэв, 2006). Манай улстай 4709,6 км хэсгээр хилээ албан ёсоор тогтоож, НҮБ-аар баталгаажуулсан. Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1994 онд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай” гэрээг шинэчлэн байгуулсан (П.Сүндэв, 2006). Энэхүү гэрээ нь хоёр улсын одоогийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1994 онд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний 1 дүгээр зүйлд:

“Хэлэлцэн тохирогч талууд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш, харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” (П.Сүндэв, 2006) гэж заасан нь хоёр улсын харилцааны суурь зарчим болж байна.

1949-2015 онд хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлуудыг зохицуулсан 450 гаруй гэрээ байгуулагдсанаас 200 гаруй гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

БНХАУ-ын үндсэн хууль (П.Сүндэв, 2006) -д зааснаар зэвсэгт хүчин нь Хятадын ардын чөлөөлөх арми /ХАЧА/, Ардын зэвсэгт цагдаа /АЗЦ/, мөн нөөц хүчин гэсэн гурван салбар хэсгээс тогтолцоо нь бүрддэг.

ХАЧА нь одоо 2 сая 255 мянган цэрэгтэй. Дотроо хуурай замын цэрэг /ХЗЦ/, Агаарын цэргийн хүчин /АЦХ/, Пуужинт цэргийн хүчин /ПЦА/- ээс тус, тус бүрдэнэ.

Хятад улс нь өөрийн үндэсний цэргийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, техник, зэвсэг, хэрэгслээр өөрийгөө бүрэн хангадаг онцлогтой (Б.Даваадорж, 2011).

БНХАУ-ын иргэн бүр эх орноо батлан хамгаалах үүргийг нэр төрийн хэрэг гэж үздэг, бүх нийтээр цэргийн алба хаах

тогтолцоотой улс юм. Жил бүр цэргийн албанд бүртгэгдсэн 18-22 насны 12 сая эрчүүдээс шаардлагатай тоогоор цэрэг авдаг. 36-45 насны эрчүүдийг цэргийн албанд татвал 400 сая цэрэг албанд мордох дайчилгааны нөөцтэйгөөс 200 сая ямар ч бэрхшээлгүй албанд тэнцэнэ гэж үздэг. БНХАУ-д цэргийн алба нь жинхэнэ алба, бэлтгэл үүрэгтэн, мөн иргэний цэрэг /цэргийн алба хаах бололцоотой боловч жинхэнэ алба хаагаагүй иргэд/ гэсэн 3 хэсгээс бүрддэг байна.

Бэлтгэл үүрэгтэн иргэний цэрэг нь хэдийгээр цэргийн бус ч орон нутаг, дүүрэг, сум, гацаанд бүртгэлтэй, тасаг салаа, суман, анги, нэгтгэлийн. зохион байгуулалттай, зэвсэглэл техник нь тодорхой цэргийн анги баазад хадгалагдаж байдаг учраас 2-5 долоо хоногийн дотор байлдааны ажиллагаанд шилжихэд бэлэн байхаар бэлтгэгдсэн байдаг. Дарга нарын боловсролыг дунд, дээд гэж ялган 300 гаруй цэргийн мэргэжлээр 4 жилээс доошгүй хугацаагаар сургаж 200 мэргэжлээр бакалаврын боловсрол олгон төгсөхөд нь дэслэгч цол олгодог байна. Офицеруудыг шат ахиулан бэлтгэх тогтолцоо одоо ч хэвээр байдаг (П & Плименко А, 2014).

“Стратегийн хил хамгаалах бодлого”-ыг

хэрэгжүүлэхэд иргэний цэрэг гэж нэрлэдэг олон нийтийн цэрэгжүүлсэн байгууллага нь улсын хил чухал объект, дэд бүтэцтэй газруудыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулахад ХАЧА ба Хилийн цэргийн анги салбарт туслах, дайны үед дайчилгааны нөөцийг бүрдүүлж цэрэг армийн байлдааны ажиллагаа, ар талыг хангахад оролцох үүрэг хүлээдэг ба улсын хил манах, хязгаар нутаг, улс, нийгэм ард түмний эрх ашгийг хамгаалах явдал нь Хятадын төрийн бодлогод улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах бодлогын нэгдмэл нэгдмэл шинжийг илэрхийлдэг¹.

Асар хүчтэй, найдвартай үндэсний батлан хамгаалах салбарыг хөгжүүлэх нь БНХАУ-ын цэргийн шинэчлэлийн стратегийн гол зорилтын нэг бөгөөд улсын ерөнхий төлөвлөгөөний дагуу үндэсний батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчнийг шинэчлэх стратегийг:

1. 2010 онд бат бэх суурийг тавьсан байх

2. 2020 онд харьцангуй өндөр хөгжилд хүргэх

3. 21 дүгээр зууны дунд үе гэхэд Зэвсэгт хүчнийг мэдээлэл зүйн технологи ашигласан дайнд ялалт байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлж байна².

¹ Ш.Лхачинжав. “Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах

ажиллагааг боловсронгуй болгох нь” диссертац 2004 он.

² Б.Даваадорж. Хятадын чөлөөлөх арми өнөө ба ирээдүй. УБ. 2011.

БНХАУ-ын “Цэргийн шинэчлэлийн бодлого”-ын хүрээнд 2019 онд Хятадын ардын чөлөөлөх армийн бүтцэд өөрчлөлт оруулснаар Цэргийн төв зөвлөл нь бүтэц, зохион байгуулалт /бүдүүвч №1/-ын хувьд ерөнхий газар 7, хороо 3, ажлын алба 5, стратегийн байлдааны тойрог 5, төрөл мэргэжлийн 5 цэрэгтэй болж өөрчлөгдсөн.

БНХАУ-ын хил хамгаалах чиг үүргийг Батлан хамгаалах дайчилгааны ерөнхий газар хэрэгжүүлэх болсон ба ХАЧА-ийн стратегийн байлдааны 5 тойргоос Монгол Улстай хиллэдэг хэсэгт Баруун бүсийн болон Хойд бүсийн байлдааны тойргууд хил хамгаалалтыг зохион байгуулж байна¹. Үүнд:

- БНХАУ-ын Баруун бүсийн байлдааны тойрог нь Шинжаан, Си Чуан, Чун Чинь, Ганьсу, Төвд, Ниньша, Чинхайн цэргийн тойргуудыг удирддаг. Шинжааны цэргийн тойргийн Алтайн, Цонжийн, Хамигийн хилийн төлөөлөгч нар баруун уулзварын цэгээс Монгол-Хятадын хилийн 500 дугаар тэмдэг /хилийн 7 дугаар отрядын хариуцсан хэсэг/ хүртэлх 1518,6 км хилийн хэсгийг хариуцан хил хамгаалалтыг зохион байгуулдаг.

- Хойд бүсийн байлдааны тойрог нь манай улсын зүүн болон өмнөд хэсэгтэй хил залгаж, Далай

хөвийн, Эрээний, Улиастайн, Амгалан, Манжуурын хилийн төлөөлөгч нар Монгол-Хятадын хилийн 500 дугаар тэмдгээс зүүн уулзварын цэг хүртэлх 3191 км хэсгийг хариуцан хил хамгаалалтыг зохион байгуулж байна.

БНХАУ-ын Засгийн газрын тогтоолоор 2018 оны 03 дугаар сард НАХЯ-ны харьяа Хил хамгаалах байгууллагад бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт явуулж БНХАУ-ын Цагаачлалын удирдах газрыг НАХЯ-ны бүтцэд байгуулж 2018 оны 04 дүгээр сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Хятадын хил хамгаалалт дараах онцлогтой байна. Үүнд:

✓ Эдийн засгийн давуу талаа ашиглан хилийн инженер техникийн хангалтыг үндсэндээ шийдсэн. Хилийн дагуу 2м өндөртэй бетонон шонтой торон хашааг босгосон. Хилийн дагуух замаа бүрэн засварласан. Хилийн станц, ротууд ачааны болон суудлын автомашин, мотоцикл, цасны чарга өргөн ашиглах болсон. Говь, тал хээрийн бүсэд бие биеэ харсан хянах цамхгууд байгуулсан.

✓ Улсын хилийг Хятадын ардын чөлөөлөх армийн анги нэгтгэлүүд хамгаалж, шалган нэвтрүүлэх боомт, түүний зурвас, гүнийг НАХЯ-ны хилийн цэрэг хамгаалдаг.

¹ МУ-ын УАБЗ-ийн Стратеги судлалын хүрээлэн “Шинэ эриний хятадын батлан хамгаалах цагаан ном-2019” 2021 он.

✓ Хятадууд улс төр, дипломатын аргаар улсын хилийг хамгаалахад онцгой анхаарч байна.

✓ Улсын хилийг өдрийн цагт тусгай төхөөрөмжилсөн хянах цамхаас хянаж, шөнийн цагт хилийн манаагаар хил хамгаалалтыг зохион байгуулж байна.

✓ Хил хамгаалалтайд тагнуулын байгууллага асар том үүрэг гүйцэтгэж байна. Тагнуулын ажилтнууд хилийн төлөөлөгчийн орлогчийн хэмжээнд ажилладаг бөгөөд тэд их эрх мэдэлтэй байгаа нь ажиглагддаг.

✓ Хил орчмын ард иргэдийг хил хамгаалалтад тусгай үүрэгтэйгээр оролцуулж тэднийг хилийн цэрэг байнга шалгаж үүрэгжүүлж байдаг.

✓ Хилийн тухай хууль тогтоомжоо чангатгасан. Хилийн дэглэм зөрчсөн, малаа хил давуулсан хүмүүст өндөр торгууль оногдуулдаг. Иймээс иргэд хилээ, хилийн цэргээ хүндэтгэдэг.

✓ Хилийн албаны гол гол албан тушаалд хятад хүмүүс томилогдсон хэвээр байна.

✓ Хил дээр ажиллаж буй албан хаагчдын цалин хангамжийг байнга нэмэгдүүлж байна. Хилчид авилгалд өртөх, хилийн зөрчилд холбогдвол тухай бүрд нь арга хэмжээ авч байна.

✓ ХАЧА болон дотоодыг

хамгаалахын цэргийн албан хаагчдын улс төр байлдааны бэлтгэл сургуульд ихээхэн анхаарч байна. Хилийн уулзалт хэлэлцээний үед буудлага хийлгэх, олон төрлийн дасгал гимнастик хийж үзүүлэх зэргээр өөрийн цэргийн сүр хүчийг гайхуулдаг болсон.

2. Оросын Холбооны Улсын хил хамгаалалт:

БНХАУ нь Монгол Улсын хөрш бөгөөд манай улстай хиллэдэг хилийн хэсэгт ОХУ-ын Холбооны Хилийн албаны Өвөрбайгалийн бүс нутгийн удирдах газрын Акташ, Кызыл, Хиагт, Мангут, Даурын хилийн отряд улсын хилийн хамгаалалтыг явуулж байна. ОХУ-ын Хакасын нийслэл Абакан хотод Акташ, Кызылийн хилийн отрядыг, Чита мужийн Акшийн районы төв Акша хотод Хиагт, Мангут, Даурын отрядуудыг тус тус шуурхай удирдлагаар хангах үүрэг бүхий оператив цэргийн бүлэг ажилладаг¹.

Хилийн отряд бүр хилийн төлөөлөгчийн аппараттай юм. Хилийн төлөөлөгчийн аппарат нь хилийн хамгаалалтыг удирдан зохион байгуулдаг бөгөөд хилийн хамгаалалтаа хилийн отряд, заставуудын бие бүрэлдэхүүн, инженер техникийн хэрэгсэл, орон нутгийн туслах хүчин, гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэлд тулгуурладаг. Хилийн

¹ В. В. Кудинов. Защита и охрана государственной границы: проблемы

Конституционноправового регулирования. 2015г.

төлөөлөгчийн аппарат нь хилийн отряда, хилийн отряд нь коминдатура, коминдатур нь хилийн заставуудаа өдөр тутмын удирдлагаар хангаж ажилладаг байна.

Оросын Холбооны Улсын хил хамгаалалт дараах онцлогуудтай байна. Үүнд:

✓ Улсын хилийг гүйцэтгэх ажлын хэрэгслээр хамгаалах, халхлахад онцгой анхаардаг. Энэ нь хил хамгаалалтын гол арга хэлбэр болсон.

✓ Улсын хил хамгаалалтад орон нутгийн ард иргэд, хилийн цэрэгт туслах хүчийг өргөнөөр ашиглахын зэрэгцээ сайн дурын ардын тусгай бүлэг, казакуудын уламжлалт бүлгүүдийг (казачество) зохион байгуулан удирдлагаар ханган ажиллуулж байна.

✓ Улсын хил хамгаалалтад орон нутгийн байгууллага, удирдлагуудын оролцоог шефийн холбоо тогтоох хэлбэрээр өргөн ашиглаж эдийн засгийн ихээхэн тусалцааг авдаг.

✓ Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах үүргийг отрядын удирдлагаас салган тусгай мэргэшсэн бүрэлдэхүүнээр явуулдаг болсон.

3. Израил улсын хил хамгаалалт

Израил улс нь улсынхаа хил хамгаалалтыг үндсэндээ техникжүүлсэн бөгөөд хил хамгаалалтын түвшнээрээ дэлхийд дээгүүрт тооцогддог. Иймээс хөрш зэргэлдээ орнуудын хил хамгаалалтын зэрэгцээ хил

хамгаалалтыг сайн зохион байгуулдаг зэвсэг техникээрээ дэлхийд дээгүүр тооцогдох болсон.

Энэ байгууллага нь зарим талаараа зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэдэг боловч, БХЯ-нд шууд захирагддаггүй. Мөн Франц, Итали, Испанитай адил Дотоод явдлын яамандаа захирагддаггүй. Харин Үндэсний цагдаагийн бүрэлдэхүүн хэсэг юм.

Хил хамгаалалтын өдөр тутмын удирдлагыг түүний дарга хангадаг бөгөөд Үндэсний цагдаагийн ерөнхий байцаагчид захирагддаг. Хил хамгаалах байгууллага нь 1953 онд байгуулагдсан бөгөөд түүний үйл ажиллагаа төрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулагддаг, байгуулагдсаныхаа эхэн үед нүүдэлчин омог бедунчуудын улсын хилийг хууль бусаар зөрчих явдалтай тэмцэхэд чиглэгдсэн байжээ.

Цаг хугацаа өнгөрөх тусам байгууллагын үүрэг улам өргөжин өөрчлөгдөх болов. Энэ нь Израил улс болон түүний эзэлсэн нутаг дэвсгэр дээр алан хядах ажиллагаа ихэссэн мөн Палестины болон Ливаны "Хезболлох" зэвсэгт бүлгүүдийн үйл ажиллагаа хил орчмын нутаг дэвсгэрт идэвхэжсэнтэй холбоотой.

Орчин үед Израилын ХХБ нь сайн сургаж бэлтгэсэн сайтар зэвсэглэгдсэн бие бүрэлдэхүүнтэй анги, салбарууд нь үндсэндээ 1967, 1973 оны Араб, Израилын

дайны дараах эзэлсэн нутаг дэвсгэрүүд болон Тель - Авив, Иерусалим хотуудад байрладаг.

1974 оноос хойш Засгийн газрын шийдвэрээр Израйлын хилийн цэрэг хот болон хөдөөгийн районы аюулгүй байдлыг хангах агаарын болон далайн усан боомт, улс ардын аж ахуй, үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтцийн онц чухал объектуудыг хамгаалах болсон.

Гадаадын цэргийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Израйлын хилийн цэрэг өнөөдрийн байдлаар алан хядах ажиллагаатай тэмцэх гол хүч болжээ.

Мөн тодорхой үүргийн хүрээнд зэвсэгт хүчин болон цагдаагийн зарим үүргүүдийг биелүүлдэг байна. Тухайлбал: Иордан голын баруун эрэг болон газрын зурваст дэг журам сахиулах, Палестины нутаг дэвсгэрт армийн анги салбарууд тусгай ажиллагаа явуулахад туслах, Палестины цагдаагийнхантай хамтарсан эргүүл хийх, онц чухал объектыг хамгаалах гэх мэт.

Хил хамгаалах байгууллага нь мөн цагдаагийн ердийн үүргийг биелүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг сахиулах сайн дурын байгууллагатай ажиллах зэрэг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд цагаачдын хөдөлгөөнд хяналт тавих, төмөр зам, агаарын болон усан замын буудлуудад дэг журам сахиулах, агаар, усан, хуурай

хилээр нэвтрэх ажиллагааг хянах, дамын наймаа, хар тамхитай тэмцэх, тусгай албадын ашиг сонирхолд зориулан хилийн зурвас дахь цагийн байдлын мэдээг цуглуулан боловсруулах үүрэгтэй.

Мөн байгалийн гамшиг болон бусад шаардлагатай нөхцөлд аврах, сэргээн босгох ажиллагаанд оролцох үүрэг хүлээдэг. Хилийн хамгаалалтад 8000 хүн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үндсэндээ ЗХУ болон Эфиопоос гаралтай еврейчүүд юм.

Бие бүрэлдэхүүний 12 хувь буюу 960 орчим нь үндэсний цөөнхийн төлөөлөл, ХЦ-г алба хаах хугацаа 3 жил, 1996 оноос эхлэн ХЦ-ийн байлдааны анги салбарт эмэгтэйчүүд алба хаадаг болсон. Хил хамгаалах байгууллагын дарга нь 6 бүс нутгийн удирдлагаас бүрдэх штабаар дамжуулан удирдлагыг зохион байгуулдаг хил хамгаалалтын байгууллагын анхан шатны нэгж нь рот бөгөөд алан хядах ажиллагаатай тэмцэх, нийгмийн дэг журмыг сахиулах болон бусад ажиллагааг чадварлаг гүйцэтгэдэг. Гол сургалтын төв нь Иерусалим хотын ойролцоо Бейт-Хоронд байрладаг.

Сургалтын төлбөр нь цагдаагийн ажиллагаа болон хуурай замын цэргийн тактик ажиллагаанд сурахад чиглэдэг. Алан хядах ажиллагаатай тэмцэх тусгай асуудлыг Үндэсний цагдаагийн сургуульд судалж, хотын нөхцөлд байлдаан явуулах,

тактик ажиллагаа, барилга байгууламж, объектыг дайран эзлэх, төр засгийн өндөр албан тушаалтнуудыг хамгаалах арга ажиллагаанд сургадаг. Сургалтыг байлдааны ойртуулсан нөхцөлд явуулж, буудлагыг будагтай сумаар үйлддэг. Ердийн хил хамгаалах анги, салбараас гадна тусгай салбарууд үүрэг гүйцэтгэгдгээс хамгийн том нь "Ямам" юм.

1974 онд байгуулагдсан энэ анги нь барууны цэргийн мэргэжилтнүүдийн дүгнэлтээр бол дэлхийн хамгийн сайн бэлтгэгдсэн тусгай салбаруудын нэг бөгөөд алан хядах ажиллагаатай тэмцэхэд арми, цагдаад туслах, барьцаалагчдыг чөлөөлөх, төр засгийн тэргүүнүүдийг алан хядах ажиллагаанаас хамгаалах тусгай үүргийг биелүүлдэг¹.

Хил хамгаалах анги, салбар, цэргүүд нь тусгай хэрэгслээр сайтар хангагдсан бөгөөд хамгаалалтын малгай, хантааз, орчин үеийн холбооны хэрэгсэл, дуу чимээний ба хийн гранат, шөнийн дуран харааны хэрэгсэлтэй бөгөөд туулц сайтай, хуягласан, сум үл нэвтрэх шилтэй, шатаах зэвсгээс бүрэн хамгаалагдсан "Суфа" маркийн

жийп автомашин ашигладаг.

Сүүлийн үеийн хил хамгаалалтад хилийн инженерийн ажлыг гүйцэтгэх зориулалттай мини-тракторуудыг өргөнөөр ашиглаж байна.

Израил улс нь улсын хилээ компьютерын бүрэн хяналтад авсан бөгөөд уг систем нь нэг оператор нь компьютерын тусламжтайгаар 250км урт хилийн хэсгийг хянах, мэдээллийг цуглуулах боломжтой. Хяналт хийхэд хүндрэлтэй хэсгийг шалгахдаа операторын удирдлагаар нисгэгчгүй нисэх онгоц хөөргөн зураг авч, боловсруулалт хийн цагийн байдлыг үнэлдэг. Уг онгоц агаарт тасралтгүй 3 цаг нислэг үйлдэх боломжтой².

Хил хамгаалах байгууллага нь Израилын аюулгүй байдлыг хангах, улсын хилийг хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж байна гэж гадаадын цэргийн мэргэжилтнүүд өндрөөр үнэлсээр байна.

Израил улсын хил хамгаалалт нь дараах онцлогуудтай байна. Үүнд:

✓ Улсын хилээ техникийн бүрэн хяналтад авсан. Энэ нь өртөг өндөртэй боловч нэгэнт байгуулагдсан тохиолдолд хүн

¹ Доклад секретариата Конференции Организации Объединенных Наций по торговле и развитию об экономических последствиях израильской оккупации для палестинского народа: бремя дополнительных ограничений в зоне С, 2000–2020 годы.

² С.В. Мелконян. Политика государства израиль в отношении Сирийской арабской республики (2009–2019 гг.), диссертация на соискание ученой степени кандидата исторических наук, специальность 5.6.7. – история международных отношений и внешней политики

хүч хэмнэсэн, ашигт үйлийн коэффициент өндөр, найдвартай хамгаалалт, халхлалтыг бий болгодог.

✓ Хүн нэг бүр, анги салбаруудын бэлтгэлийн түвшин өндөр, орчин үеийн зэвсэг техник хэрэгслээр бүрэн хангагдсан.

✓ Хил хамгаалах байгууллага нь улсын хил хамгаалалтаас гадна тусгай үүргүүдийг гүйцэтгэдэг бөгөөд уг чиглэлээрээ өндөр дадлага чадвар эзэмшсэн, мэргэшсэн.

✓ Хил хамгаалах байгууллагын дарга нь бүс нутгийн удирдлагаар дамжуулан удирдлагыг зохион байгуулдаг.

4. Америкийн нэгдсэн улсын хил хамгаалалт

АНУ 2002 онд Дотоод аюулгүй байдлын тухай хуулийн баталснаар Дотоодыг аюулаас хамгаалах яам байгуулагдаж хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээх болсон. Тус яам нь хилийн хяналтад шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэх бодлого, стратегийг хэрэгжүүлдэг. Хилийн аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр нисгэгчгүй нисэх хэрэгсэл /дрон/, мэдрэгч системүүд, хяналтын камеруудыг ашиглаж байна.

АНУ-ын хил, гаалийн хяналтын алба нь хилийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор

автономит хяналтын цамхгуудыг хилийн дагуу байрлуулж сэжигтэй хөдөлгөөнийг хиймэл оюун ухаан ашиглан илрүүлэх, хилийн хяналтад нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглаж, алслагдсан болон бартаатай хэсэгт хяналт тавьж, хилийн боомтуудад биометрийн төхөөрөмжүүдийг өргөнөөр ашигласнаар АНУ-ын хилийн аюулгүй байдал, хяналт сайжирч, хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чадвараа нэмэгдүүлсэн.

АНУ-Мексикийн хилийн хамгаалалтын хамгийн удаан хугацааны туршлагаас үзэхэд хилийн хяналтыг огцом чангаруулах нь урьдчилан тооцоолоогүй сөрөг нөлөө үзүүлж болохыг харуулж байна.

АНУ-ын засгийн газраас 1990-ээд он, 2000 оны эхэнд авч явуулсан өргөн хэмжээний арга хэмжээ нь үнэндээ өмнө нь Мексикээс ирээд буцдаг байсан түр зуурын хууль бус цагаачдыг үй олноороо АНУ-д суурьшиж үлдэхэд хүргэсэн юм.

Нэр хүнд бүхий эрдэм шинжилгээний байгууллага¹-ын, судалгааны дүнгээр 1995 оноос 2004 он хүртэл АНУ-д амьдардаг хууль бус цагаачдын тоо 2.2 саяас 6.2 сая болж өссөн байна².

Үүнээс гадна хууль бус

¹ “The Pew Research Center for the People & the Press”

² Passel J. Size and Characteristics of Unauthorized Migrant Population in the

U.S. Estimates Based on the March 2005 Current Population Survey. Pew Hispanic Center: <http://pewhispanic.org/reports/report.php?ReportID=61>

цагаачдыг зөөвөрлөх нь ашигтай, далд бизнес болон хувирч хилийн саад тотгорыг даван туулахад мэргэшсэн Мексикийн мафийн бүлгийн нөлөөг урьд хожид үзэгдээгүйгээр бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан байна¹.

Мансууруулах бодис худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор хилийн саад байгуулах нь бүр ч үр дүн муутай бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтнүүд хар тамхи, мансууруулах бодисыг хилийн шалган нэвтрүүлэх боомтоор гаргах илүү сонирхолтой байдаг. Учир нь овор багатай барааг хил дамнасан их хэмжээний урсгалд нуух нь түүнийг илрүүлэх хилчдийн чадавх, боломжоос хэд дахин давдаг, зарим хар тамхи зөөвөрлөгчид баривчлагдах нь мансууруулах бодисын зохион байгуулалттай бизнест шальтай хохирол учруулдаггүй байна.

Хилийн саадыг нэвтрэхийн тулд мансууруулах бодисын гэмт хэргийн бүлэглэлийнхэн, хууль бус цагаачид шууданч шувуу ашиглах, хилийн торон саад доогуур шуудуу ухах, мансууруулах бодис шидэж давуулах гэх мэт аргуудыг хэрэглэдэг. Энэ тохиолдолд хилийн хаалт, саад босгох нь маш өндөр өртөгтэй, үр ашиг багатай арга хэмжээ болох нь ажиглагддаг.

Хилийн хана, хашаа болон бусад хатуу саад хаалтыг барих талыг баримталсан улс орнуудын туршлагыг адилхан үнэлж болохгүй билээ. Зарим тохиолдолд, эмх замбараагүй байдлаас зайлсхийх хууль бус цагаачид, террористуудын урсгалыг бууруулах зайлшгүй шаардлагатай арга хэмжээ ч болж байжээ. Гэвч гэмт хэрэгт холбогдогсод ихэвчлэн шинэ нөхцөл байдалд дасан зохицож, энэ арга хэмжээний үр дүнг бууруулдаг.

Үүнээс гадна энэ бодлогыг дэмжигчид улс орнууд нь ихэвчлэн хөрш орнуудтайгаа харилцах харилцаа хүндрэх, хилчид болон гаальчдын дунд авлигын түвшин нэмэгдэх, хүний эрхийн зөрчил нэмэгдэж, үр дүнд нь улс орны нэр хүндийг унагах зэрэг сөрөг үр дагавартай тулгардаг. Эдгээрээс үзэхэд хилийн хана, хашаан саадыг барьж байгуулах ажлыг хил дээрх нөхцөл байдлыг хэвийн болгох хосгүй жор гэж үзэж болохгүй.

Аюулгүй байдлаа хамтын хүчээр хангадаг АНУ-Канадын туршлагаас харахад хилийн аюулгүй байдлын салбарт хөрш оронтойгоо хамтран ажиллах ялангуяа хил хамгаалалтын хамтын системийг бүрдүүлэх нь бусад загваруудаас илүү үр дүнтэй байдаг. Энэ стратеги нь хөрш оронтойгоо тогтоосон сайн

¹ Голунов С.В 2008. Безопасность американо-мексиканской границы: опыт пограничной политики США // США –

Канада: экономика, политика, культура. Вып 4.

харилцааг хадгалж, бэхжүүлдэг. Хил, гаалийн үйл ажиллагааны илүү давхардлыг арилгаж, их хэмжээний үргүй зардлыг хэмнэх, хил дамнасан урсгалд тохиолдох саад бэрхшээлийг багасгахад үр өгөөжтэй байдаг. Энэ сонголт нь хамтрагч талуудын хоорондын бүрэн дүүрэн харилцан итгэлцэл, хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх сонирхол, хилийн аюулгүй байдлын бодлогыг бүрдүүлэх ажиллагааны үеийн харилцан буулт хийхэд бэлэн байдал, энэ бодлогын зарчим, стандартуудын нэгдэл зэргээс хамаарна.

Хөрш оронтойгоо нягт хамтран ажиллах үндсэн дээр хилийн аюулгүй байдлаа хангахын нэг тод жишээ нь Америк-Канадын хилийн хамгаалалт юм. Дэлхийн хамгийн урт энэ хил нь /хуурай газрын хил нь ойролцоогоор 8900 км/ эдийн засгийн өндөр хөгжилтэй гадаад худалдааны түнш найрамдалт улсуудыг заагладаг. Хилийн шалган нэвтрүүлэх 11 боомтоор хил дамнасан урсгалын 90 хувь буюу 1 секунд тутамд 1 тээврийн хэрэгсэл, 6 секунд тутамд 1 ачааны машин шалган нэвтрүүлж байна¹. XX зууны туршид Америк-Канадын хил нь 1930–аад оны Канадын ерөнхий сайд Р.Беннетийн хэлснээр хамгийн том харилцан худалдааны

эргэлттэй “дэлхийн хамгийн урт хамгаалалтгүй хил” байжээ².

2001 оны 9 дүгээр сарын 11 ний террорист халдлагын дараа хойд хил нь АНУ-ын засаг захиргааныхны хувьд “Террористуудын нэвтэрч болох нэгэн гол чиглэл” гэж үзэгдэх болов. Үүнээс хойш Вашингтоноос хилийн хяналтыг чангатгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хил дамнасан тээвэрт ноцтой хохирол учруулсан юм. Ерөнхийдөө хоёр улс, ялангуяа Канадын талд эдийн засаг, гадаад худалдаанд нь асар их хохирол учруулж бараа эргэлтийн хэмжээ эрс буурах аюул тулгарсан. Энэ нөхцөлүүдэд талууд хил дамнасан урсгалуудыг хянах хамтын системийг бүрдүүлэхээр ажилласан юм. 2001 оны 12 дугаар сарын 12-нд Оттавад “Ухаалаг хил”-ийн талаарх мэдэгдэлд гарын үсэг зурцгааж, түүнд итгэл хүлээсэн жуулчид болон худалдааны байгууллагад аль болох таатай журам боловсруулах, эдгээр байгууллагын эд бараанд тавих хяналтыг хилийн бүсээс ачаалах цэгүүдэд шилжүүлэх, хил дээрх чирэгдлийг багасгахын тулд шалган нэвтрүүлэх боомтуудыг сайжруулах зэрэг шинэ стратегийн давуу талыг

¹ Bureau of Transportation Statistics: <http://www.transtats.bts.gov/bordercrossing.aspx>

² Безопасность и международное сотрудничество в поясе новых границ

России. 2002 / Под ред. Л.Б.Вардомского, С.В.Голунова. М.; Волгоград: Научно-образовательный форум по международным отношениям.

тунхагласан юм¹.

5. Европын холбооны улсын хил хамгаалалт

Нээлттэй хил нь хялбар биш нөхцөлүүд болох эдийн засгийн болон гаалийн нэгдмэл бодлого, хөрш орны хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа, хилийн нэгдмэл орон зайг бүрдүүлэх тодорхой стандарт бүхий гадна хилийн хяналт зэргийг биелүүлэхийг шаарддаг.

Ийм ажиллагааны шилдэг загвар нь Европын Холбоо юм. Европыг холбоо нь тодорхой тогтоосон хилгүй, хил хамгаалах төвлөрсөн системгүй. Гэвч Европын холбооны бараг бүх гишүүн орнуудын хилийн бодлого нь ихэнх тохиолдолд зайлшгүй мөрдөх ёстой нийтлэг зарчим, дүрэм дээр тулгуурладаг.

Европын холбооны хилийн аюулгүй байдлыг хангах бодлогын гол агуулга нь Европын холбооны дотоодын хилийн хяналтыг түүний дүрэмд үндэслэн өөрчлөх ялангуяа бүс нутгийн улсуудын хоорондын хилийн хяналтыг өөрчлөх үйл ажиллагаагаа юм. Энэ нь хууль бус цагаачлал, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд Европын холбооны улсуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хилийн гадаад хяналтыг чангатгах байдлаар нөхөгдөх ёстой. Хилийн гадаад хамгаалалтын системд хил

дамнасан хууль бус ажиллагаатай тэмцэхэд Европын холбооны нэгдсэн бүтэц болон механизмууд нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Тэдгээрийн нэг нь –виз, зөвшөөрөл хүсэгчид, хууль дүрэм зөрчигчид, алга болсон эд зүйлс гэх мэтийн талаар хилчдэд шаардлагатай бүх мэдээллийг өгдөг “Шенгений мэдээллийн нэгдсэн систем” юм.

Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд гол үүргийг хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн солилцоо зохион байгуулах, тагнуулын мэдээг үнэлж дүгнэх, санал боловсруулах ажлуудыг гүйцэтгэдэг байгууллага болох “Европол” биелүүлнэ. Европын холбооны гишүүн улсуудын хилийн бодлогыг зохицуулах, мэдээлэл, туршлага солилцлыг зохион байгуулахын тулд 2004 онд Европын холбооны гишүүн улсуудын хилийн гадаад оперативын хамтын ажиллагааны удирдлагын Европын агентлаг “ФРОНТЕКС” - ийг байгуулсан байна. ФРОНТЕКС нь Европолын адил бүтэц болон гүйцэтгэх засаглалын эрхгүй, зохицуулах байгууллага юм.

Европын холбооны гадаад хилийг хамгаалах зардлыг тэгш хуваарилаагүйгээс болж ийм хилтэй болон хилгүй улсуудын

¹ Smart Border Declaration. Building a Smart Border for the 21st Century on the Foundation of a North American Zone of Confidence. 2001 // Foreign Affairs and

International Trade Canada: http://geo.international.gc.ca/can-am/main/border/smart_border_declaration_e.n.asp

хооронд зөрчил, гомдол гарч байна. Гэвч хил хамгаалалтын нэгдсэн бодлого боловсруулахад саад болж байгаа хамгийн ноцтой бэрхшээл нь Европын холбооны улсуудын эрх зүйн системийн ялгаа байсаар байна¹.

Шинэ гишүүн орнууд болон Европын холбооны гишүүн болохоор хүлээгдэж байгаа орнуудын хилчид болон гаалийн ажилтнуудад эдгээр албануудыг энгийн болгох, ШНБ-уудыг компьютержуулах, орчин үеийн тоног төхөөрөмжийг хил дээр ашиглах, хүний эрхийг хүндэтгэх гэх мэт стандартын шаардлагуудыг тавьж байна. Хэдийгээр эдгээр шаардлагууд нь зөвлөмжийн шинжтэй боловч эдгээрийг биелүүлэхгүй байх нь ялангуяа холбоонд шинээр элсэхийг хүсэж байгаа орнуудын хүсэлтийг хүлээж авахгүй байх шалтаг болж мэдэх учраас эдгээр улсууд дээрх шаардлагуудыг гуйвалтгүй мөрдөж байна. Европын холбооны хилийн гадаад аюулгүй байдлыг хангахад ялангуяа энэ үүргийг хүлээж байгаа гишүүн орнуудын хувьд техник, эдийн засгийн тусламж, хөнгөлөлт үзүүлэх, гаалийн орлогын 25 хувийг өөртөө авч үлдэх эрх олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг².

Европын холбоог өргөтгөх явцад хуучин социалист лагерийн орнуудтай нягт хамтын ажиллагааг хөгжүүлснээр хилийн гадаад аюулгүй байдлын бэрхшээлтэй асуудлуудыг арилгаж эдийн засгийн шинэчлэл, хууль хэрэгжүүлэх болон бусад хүрээний Европын нийтлэг стандартыг мөрдөж байна. Шилжилтийн урт хугацаанд эдгээр улсууд нь Европын холбооны хилийн нийтлэг орон зайд нэгдэж, хилээ хамтран хамгаалж байна. Европын холбооноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь мансууруулах бодис, хууль бус хилийн зөрчлийн эсрэг тэмцэлд мэдэгдэхүйц үр дүнд хүрээгүй байна.

Дүгнэлт

Аливаа улс үндэстний хувьд хилийн аюулгүй байдлаа хангана гэдэг нь юуны өмнө төрийн тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдал, ард иргэдийнхээ оюун санааны нэгдмэл чанарыг хилийн орон зайд хамгаалан бэхжүүлэхээс эхлээд өөрийн ашиг сонирхол, хилийн халдашгүй дархан байдлыг бусдаар хүлээн зөвшөөрүүлэх төдийгүй түүний баталгаатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй олон талтай, баялаг агуулгатай улс төр-

¹ Anderson M. 2000. Border Regimes and Security in an Enlarged European Community: Implications of the Entry into Force of Amsterdam Treaty. EUI Working Paper № 2000/8. San Domenico: European University Institute

² Андреев, Р.Р. 1999. Sovereigns and Smugglers: Enforcing the U.S.-Mexico Border in the Age of Globalization /A Dissertation Presented to the Faculty of the Graduate School of Cornell University

дипломат, тагнуул, цэрэг, эдийн засгийн цогц бодлого, арга хэрэгсэл, үйл ажиллагааны нэгдэл юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах бодлогоо тодорхойлоход улс орны хилийн заагийн уртын хэмжээ, хязгаар нутгийн газар зүйн байдал, хил дамнасан хөдөлгөөний урсгалын ачаалал, хөрш улсын нийгэм эдийн засаг, соёлын шинж байдал, аюулгүй байдлын хурцадмал талууд зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлдгийг харгалзан үзэх чухал юм.

Иймээс хилийн аюулгүй байдлын аль нэг загварыг шууд монголын хөрсөнд хуулж буулгах нь оновчтой эсэх нь эргэлзээтэй боловч эдгээр туршлагуудыг хилийн аюулгүй байдлыг хангах бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн үед анхаарч үзэх нь чухал юм.

Эх сурвалж:

1. Монгол улс-БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ. УБ. 1994 он

2. Ш.Лхачинжав. “Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах ажиллагааг боловсронгуй болгох нь” диссертац 2004 он.

3. П.Сүндэв. Улсын хилийг хамтран шалгахад баримталсан бодлого, чиглэл. Улаанбаатар. 2006 он.

4. Б.Даваадорж. Хятадын чөлөөлөх арми өнөө ба ирээдүй. УБ. 2011.

5. Хил судлалын шинжлэх ухааны онол, практикийн зарим асуудал. ХСИС. Улаанбаатар. 2014 он.

1. МУ-ын УАБЗ-ийн Стратеги судлалын хүрээлэн “Шинэ эриний хятадын батлан хамгаалах цагаан ном-2019” 2021 он.

2. МУ-ын гадаад харилцааны яамны сайт: <http://www.mfa.gov.mn>. 2018 он.

3. 中华人民共和国宪法. 北京: 2006. 共51页 / пер. изд.: Конституция КНР. – Пекин, 2008.

4. Каменнов П., Клименко А. О военной политике и военной доктрине Китая // Проблемы Дальнего Востока. 2014. № 5. С. 126–148.

5. В. В. Кудинов. Защита и охрана государственной границы: проблемы Конституционноправового регулирования. 2015г.

6. В.А. Ширяев. Защита и охрана государственной границы российской федерации: историография 90-х гг. XX в. 2013г.

7. Доклад секретариата Конференции Организации Объединенных Наций по торговле и развитию об экономических последствиях израильской оккупации для палестинского народа: бремя дополнительных ограничений в зоне С, 2000–2020 годы.

8. С.В. Мелконян. Политика государства израиль в отношении Сирийской арабской республики (2009–2019 гг.), диссертация на

соискание ученой степени кандидата исторических наук, специальность 5.6.7. – история международных отношений и внешней политики

9. Passel J. Size and Characteristics of Unauthorized Migrant Population in the U.S. Estimates Based on the March 2005 Current Population Survey. Pew Hispanic Center: <http://pewhispanic.org/reports/report.php?ReportID=61>

10. Голунов С.В. 2008. Безопасность американо-мексиканской границы: опыт пограничной политики США // США – Канада: Вып 4.

11. Bureau of Transportation Statistics: <http://www.transtats.bts.gov/bordercrossing.aspx>

12. Безопасность и международное сотрудничество в поясе новых границ России. 2002 / Под ред. Л.Б.Вардомского, С.В.Голунова. М.; Волгоград: Научно-образовательный форум по международным отношениям.

13. Smart Border Declaration. Building a Smart Border for the 21st Century on the Foundation of a North American Zone of Confidence. 2001 // Foreign Affairs and International Trade Canada: http://geo.international.gc.ca/can-am/main/border/smart_border_declarationen.asp

14. Anderson M. 2000. Border Regimes and Security in an Enlarged European Community: Implications of the Entry into Force of Amsterdam Treaty. EUI Working

Paper № 2000/8. San Domenico: European University Institute

15. Андреас, P.R. 1999. Sovereigns and Smugglers: Enforcing the U.S.-Mexico Border in the Age of Globalization / A Dissertation Presented to the Faculty of the Graduate School of Cornell University